

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Тохижилт үйлчилгээний ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2021/137/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2021 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342315 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Энхтөр

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	10
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	15
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	15
4. Менежментийн захидал .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	17

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



### БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.24 № 95

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_т

БУЛГАН СУМЫН ТОХИЖИЛТ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЙН  
ДАРГА А.ГАНБОЛД ТАНАА

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын тохижилт үйлчилгээний ангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын тохижилт үйлчилгээний ангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

006020199



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>67,945,430.00</u></b>	<b><u>70,108,016.64</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	20,000.00	79,726.64
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	79,726.64
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	67,925,430.00	70,028,290.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	4,574,500.00	3,919,000.00
35110	Тусгай зориулалттай материал	4,574,500.00	3,919,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	63,350,930.00	66,109,290.00
35410	Бичиг хэргийн материал	296,500.00	250,000.00
35420	Аж ахуйн материал	29,769,550.00	21,963,650.00
35430	Сэлбэг хэрэгсэл	19,145,100.00	18,433,560.00
35440	Түлш, шатах тослох материал	3,553,080.00	1,029,180.00
35450	Барилгын засварын материал	7,629,000.00	18,378,100.00
35460	Хүнсний материал	1,666,250.00	3,826,850.00
35470	Бусад хангамжийн материал	1,291,450.00	2,227,950.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>8,483,503,911.49</u></b>	<b><u>8,433,970,371.49</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	8,483,503,911.49	8,433,970,371.49
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	7,526,863,911.49	7,477,330,371.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	984,728,057.85	984,728,057.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(110,339,671.63)	(125,818,933.75)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	609,706,102.00	650,706,102.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(241,317,804.51)	(257,831,615.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,041,601,359.00	1,037,094,397.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(173,831,941.68)	(184,332,139.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	312,527,104.07	303,389,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(302,191,010.83)	(293,448,349.22)
39209	Зам, гүүрийн байгууламж	2,782,003,100.15	2,799,991,700.15
39210	Хуримтлагдсан элэгдэл	(654,450,345.87)	(729,753,617.61)
39211	Баглан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	388,889.00	388,889.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(239,814.76)	(249,536.98)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	591,564,945.90	591,564,945.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,161,721,434.28	3,202,125,534.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	(475,006,491.48)	(501,224,763.27)

Тохижилт үйлчилгээний ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	956,640,000.00	956,640,000.00
39301	Програм хангамж	650,000.00	650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(150,000.00)	(150,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	956,140,000.00	956,140,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>8,551,449,341.49</u></b>	<b><u>8,504,078,388.13</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b><u>1,235,062.92</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	1,235,062.92
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	1,235,062.92
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	346,962.92
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	888,100.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	888,100.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>8,551,449,341.49</u></b>	<b><u>8,502,843,325.21</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	8,551,449,341.49	8,502,843,325.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,103,290,133.50	5,103,290,133.50
51101	Өмч: - төрийн	5,103,290,133.50	5,103,290,133.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	3,027,935,582.22	2,979,329,565.94
51210	Өмнөх үеийн үр дүн	3,027,935,582.22	3,028,121,200.30
51220	Тайлант үеийн үр дүн	-	(48,791,634.36)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	420,223,625.77	420,223,625.77
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>8,551,449,341.49</u></b>	<b><u>8,504,078,388.13</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,617,230,263.00</b>	<b>648,240,838.55</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,126,767,863.00</b>	<b>112,256,938.55</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,126,767,863.00	112,256,938.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,126,767,863.00	112,256,938.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,145,550.00	90,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,122,622,313.00	112,166,938.55
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>490,462,400.00</b>	<b>535,983,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	348,507,700.00	390,954,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	348,507,700.00	390,954,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	47,500,000.00	50,575,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,500,000.00	47,000,000.00

**Тохижилт үйлчилгээний ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,575,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	94,454,700.00	94,454,700.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	94,454,700.00	94,454,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,125,108,707.46</b>	<b>695,514,472.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,125,108,707.46</b>	<b>695,514,472.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,125,089,674.46	695,333,028.91
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	502,870,077.00	544,070,950.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	502,870,077.00	544,070,950.36
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	622,219,597.46	151,262,078.55
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	622,219,597.46	151,262,078.55
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	19,033.00	181,444.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	19,033.00	181,444.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,033.00	181,444.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>492,121,555.54</b>	<b>(47,273,634.36)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	75,991,400.00	1,518,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	75,991,400.00	1,518,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(75,991,400.00)	(1,518,000.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>416,130,155.54</b>	<b>(48,791,634.36)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>494,607,950.00</b>	<b>536,073,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,145,550.00</b>	<b>90,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,145,550.00	90,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,145,550.00	90,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,145,550.00	90,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>490,462,400.00</b>	<b>535,983,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	348,507,700.00	390,954,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	348,507,700.00	390,954,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	47,500,000.00	50,575,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,500,000.00	47,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,575,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	94,454,700.00	94,454,700.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	94,454,700.00	94,454,700.00

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	490,713,150.00	536,073,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	490,713,150.00	536,073,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	490,694,117.00	535,892,456.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	486,548,917.00	530,447,456.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	486,548,917.00	530,447,456.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,145,200.00	5,445,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,145,200.00	5,445,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,033.00	181,444.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,033.00	181,444.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,033.00	181,444.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,103,290,133.50	420,223,625.77	2,611,805,426.68		8,135,319,185.95
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,103,290,133.50	420,223,625.77	2,611,805,426.68	-	8,135,319,185.95
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	416,130,155.54		416,130,155.54
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,103,290,133.50	420,223,625.77	3,027,935,582.22	-	8,551,449,341.49
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,103,290,133.50	420,223,625.77	3,027,935,582.22	-	8,551,449,341.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	185,618.08		185,618.08
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,103,290,133.50	420,223,625.77	3,028,121,200.30	-	8,551,634,959.57
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(48,791,634.36)		(48,791,634.36)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,103,290,133.50	420,223,625.77	2,979,329,565.94	-	8,502,843,325.21

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	494588917.00	492192900.00	485447566.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	490694117.00	492192900.00	485447566.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	490694117.00	492192900.00	485447566.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	486,548,917.00	492,192,900.00	485,447,566.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	486,548,917.00	492,192,900.00	485,447,566.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	352,653,250.00	-	391,044,200.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	348,507,700.00	-	390,954,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	348,507,700.00	-	390,954,200.00
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	4,145,550.00	-	90,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,145,550.00	-	90,000.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>50,444,890.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>50,444,890.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	50,444,890.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	44,999,890.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	44,999,890.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	5,445,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,445,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	50,575,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	50,575,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	47,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,575,000.00

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Булган сумын Хот тохижилт үйлчилгээний ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг А.Ганболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд томилолтын данснаас батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж дахин давтахгүй байх талаар төлбөрийн акт тогтоож менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 21-нээс 2021 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Энхтөр хариуцаж хэрэгжүүлэв.

Булган сумын Хот тохижилт үйлчилгээний ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 13 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

“Хотынхоо өнгө төрхийг өдөр тутам байнга дээшлүүлж, нийтийн эзэмшлийн эд аж ахуйгаа эвдрэл гэмтэлгүй бүрэн бүтэн байлгаж хийц, хэлбэр, өнгө үзэмжийг тогтмол дээшлүүлэн гэрэлтүүлэг, чимэглэл, гудамж талбайн ногоон байгууламжаа байнга тордож, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг сайжруулах замаар оршин суугчдынхаа тав тухтай ажиллах, амьдрах тавтай нөхцөлийг бүрдүүлэхэд бидний эрхэм зорилго оршино.” гэсэн зорилготой. Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн байгууллагад туслах, эрхлэх үйл ажиллагааны чиглэлтэй

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Сангийн сайдын тушаал
- Шилэн дансны тухай хууль
- Холбогдох хууль тогтоомж стандартууд

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Булган сумын Хот тохижилт үйлчилгээний ангийн 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар 2019 онд орон нутаг дахь Булган сумын Хот тохижилт үйлчилгээний ангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж алдаа зөрчил илрээгүй байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар 2019 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил арилгах дараах арга хэмжээг авсан байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар 1 албан шаардлага өгч ажиллажээ.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн орлого сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын 645905.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 12918.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган сумын Хот тохижилт үйлчилгээний ангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47370.9 мянган төгрөгөөр буюу 0.55 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн нь 0 үлдэгдэлтэй үндсэн хөрөнгийг данснаас хассан, дахин үнэлсэн шалтгаантай байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	20000	79726.64	59726.64
Урьдчилгаа		8507078388.13	
Бараа материал	67925430	70028290	-2102860
Үндсэн хөрөнгө	10441030992.25	10526779326.73	-85748334.48
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8551449341.49</b>	<b>8504078388.13</b>	<b>47370953.36</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8551449341.49	8502843325.21	48606016.28
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>8551449341.49</b>	<b>8504078388.13</b>	<b>47370953.36</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй.

Авлага дансны үлдэгдэл 79.7 мянган төгрөг болж өмнөх оны авлагаас 59.7 мянган төгрөгөөр өссөн нь НДШ илүү шилжүүлсэн шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2019-2020 онуудад үүссэн, 79.7 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй авлага байхгүй. Нийгмийн даатгалтай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 70028.3 мянган төгрөг болж өмнөх оноос 2102.8 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй орлого хүлээн авсан шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2020 онд худалдаж авсан болон үнэ төлбөргүй ирсэн бараа материалаас ашиглалтгүй бараа материал байхгүй.

Оны эцэст 1029.2 мянган төгрөгийн шатахуун худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь оны эхэнд санхүүжилт сарын сүүлд орж ирдэг тул нөөцөлж авах шаардлага үүссэн байна.

Бараа материалын дансанд 2019-2020 онуудад хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгө харьяа байгууллагууд болон захиалагч байгууллагад шилжүүлээгүй бүртгэл байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10526779.3 мянган төгрөг болж өмнөх оноос 85748.3 мянган төгрөгөөр өссөн нь шинээр тээврийн хэрэгсэл, гэрэлтүүлэг, зам гүүрний байгууламж орлогоор авсан шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 1178.1 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 100550.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй, акталсан 15980.2 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1235.06 мянган төгрөг болж өмнөх оны 1235.06 төгрөгөөр өссөн нь ХХОАТ 346.9 мянган төгрөг дутуу шилжүүлсэн, Шинэ хөдөө ОНӨААТҮГ-аас 4 жилийн хугацаатай гэрээгээр хүлэмж 1178.1 мянган төгрөг үүнээс эхний 1 дэх жилийн төлбөр 290.0 мянган төгрөгийг шилжүүлж үлдэгдэл 888.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр Шинэ хөдөө ОНӨААТҮГ-аас 4 жилийн хугацаатай гэрээгээр хүлэмж 1178.1 мянган төгрөгийн өр үүссэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2020-2023 онуудын 1178.1 мянган төгрөгийн хүлэмж худалдан авч үлдэгдэл 888.1 мянган төгрөг, нийт өр төлбөрийн 72 хувийг эзэлж байна.

Бусад 346.9 мянган төгрөгийн өр ХХОАТ-ыг дутуу шилжүүлсэн шалтгаанаас үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8551449.3 мянган төгрөг болж 48606016.28 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл, 15980.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан, шалтгаалжээ. Энэ нь тоног төхөөрөмж, ширээ сандлын хүрэлцээ муудсан байна.

Тайлант онд санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 968989.4 мянган төгрөгөөр буюу 59 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хандиваар 2 авто тээврийн хэрэгслийн орлого байна. Энэ нь нийтийн тээврийн автобус, хог тээврийн авто машин нэмэгдэж бүтээмж дээшилсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 429594.2 мянган төгрөгөөр буюу 38.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн акталсан, элэгдсэн зэрэг зардлууд шалтгаалж байна. Энэ нь тоног төхөөрөмж, тавилга эд хогшил хүрэлцэхгүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан үндсэн хөрөнгө бараа материал байхгүй, нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 949376.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 949376.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 457183.2 мянган төгрөгөөр бууруулж 492192.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ болон санхүүжүүлэх төсөв батлагдаж ирээгүй байна.

Гүйцэтгэлээр Улсын төсвөөс 390954.2 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 94454.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилт 47000.0 мянган төгрөг авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 3665.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй орлого 112256.9 мянган төгрөг, нийт 648240.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 648059.4 мянган төгрөгийг зарцуулж 181.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 648059.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь нэмэлт санхүүжилтийн зардлыг 130.1 мянган төгрөгөөр, үндсэн дансны зардлыг 51.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Булган сумын Хот тохижилт үйлчилгээний анги нь 2020 онд үйл ажиллагааны болон туслах үйл ажиллагааны орлогоос төвлөрүүлэх орлогыг баталдаагүй байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Үйл ажиллагаа, нэмэлт санхүүжилтийн данснаас хэмнэгдсэн орлогыг орон нутгийн дансанд төвлөрүүлсэн	0	181.4	181.4	100
<b>Нийт дүн</b>				

#### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 2000.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 45000.0 мянга, авто замын сангаас 45000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны

хүрээнд бий болсон нэмэлт орлого 3575.0 мянга, нийт 50575.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс нийтийн тээврийн нөхөн олговор 2000.0 мянган төгрөг, зам засвар арчлалт 45000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны зардал 3444.9 мянга, нийт 50444.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 130.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 20 мэдээллээс хугацаандаа оруулсан 3 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 15 мэдээлэл, 0 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 570.4 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Зөвлөмж аваагүй.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	570.4	2	570.4	0	0	0
Албан шаардлага	1	0	1	0	0	0	0
Зөвлөмж	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	3	570.4	3	570.4	0	0	0

/мянган.төг/

Өмнөх онд хэрэгжүүлээгүй төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжид Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3634.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 208.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 426.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын орлого илүү авсан алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Авто машины орлогыг 19000.0 мянган төгрөгөөр хүлээн авч орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэхдээ 3000.0 мянган төгрөгийг илүү тооцсон байсныг залруулав.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 208.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 208.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо.

1. Албан томилолт нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

2. Албан томилолт нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6, 13.7 дэх заалттай хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 426.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Санхүүгийн тайлан баталгаажуулалтаар тайлант онд өр, авлага үүсгэхгүй байх, албан томилолт анхан шатны баримтыг нягталж шалгаж гүйлгээ хийх ба шаардлага хангахгүй анхан шатны баримтын бүрдэл дутуу тамга тэмдэг, томилолтоор ажилласан хугацааг хаагаагүй гүйлгээг хийхгүй байх, үндсэн хөрөнгө болон бараа материалыг орлогодоход хариуцлагатай хүлээж авч баримтын үнийн дүнгээр орлогодож авах. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, хугацаа хоцроож мэдээлэхгүй байх шаардлагатай байна. Иймд дотоод хяналтын баг бүрэлдэхүүнийг томилж үйл ажиллагаа болон бусад ажил үйлчилгээг хяналттай ажиллуулах дотоод хяналтыг сайжруулах нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Өглөгийн данстай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

ХХОА Татвар дутуу шилжүүлсэн 346.9 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

###### **1.2. Эрсдэл:**

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

###### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. НББ тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;

###### **1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

##### **2. Авлагын данстай холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Нийгмийн даатгалд 79.7 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн авлага

###### **2.2. Эрсдэл:**

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

###### **2.3. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. НББ тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;

###### **2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

##### **3. Шилэн данстай холбоотой асуудал**

###### **3.1. Илрүүлэлт:**

Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй хугацаа хоцроож мэдээлсэн.

###### **3.2. Эрсдэл:**

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

###### **3.3. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах.

###### **3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
20..			САГ-2021/137/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Булган сумын Тохижилт үйлчилгээний анги</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	ХХОА Татвар дутуу шилжүүлсэн 346.9 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.	346.9	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	А.Ганболд Л.Тунгалаг
2	Нийгмийн даатгалд 79.7 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн авлага	79.7	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	А.Ганболд Л.Тунгалаг
3	Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй хугацаа хоцроож мэдээлсэн.	0	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	А.Ганболд Л.Тунгалаг
4	УБ- Өмнөговь -Дорнод туршлага судалсан томилолт	208.0	Төлбөрийн акт	Дарга Нягтлан бодогч	А.Ганболд Л.Тунгалаг
5	Үндсэн хөрөнгийн дансанд авто машины орлого илүү авсан	3000.0	Залруулсан	Дарга Нягтлан бодогч	А.Ганболд Л.Тунгалаг
<b>ДҮН</b>		<b>3634.6</b>			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Б.ЭНХТӨР